



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 5/8

Мөрөн сум

Н.Намжилноровт сахилгын шийтгэл
оноох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров) нь Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлангаар Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг зөрчсөн нь тогтоогдсон тул Төрийн албаны тухай хуульд заасны дагуу өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэл оноож хариуцлага тооцсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хуулийн дагуу сахилга хариуцлагыг чангатгаж, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР